



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
орон тооны бус зөвлөлийн журам батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” А/114 дүгээр тушаал, ШУТИС-ийн дүрмийн 4.9.15, 4.9.16, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн болон 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан журмыг хэрэгжүүлэн ажиллахыг Барилга байгууламж, дэд бүтцийн алба (Д.Орхон)-д, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын дарга (Б.Түмэндэлгэр)-д тус тус үүрэг болгосугай.

РЕКТОР



Т.НАМНАН



ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн журам	Эхний хэвлэлт	2026.03.24
	Өөрчилсөн огноо	-
	Өөрчлөлтийн дугаар	-

ШУТИС-ИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус төв зөвлөл” болон бүрэлдэхүүн, салбар сургуулийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус салбар зөвлөл” /цаашид хамтад нь “Зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагаа нь их сургуулийн хэмжээнд ажлын байр, ажиллах суралцах орчин нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.2. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу ажил олгогч хариуцна.
- 1.3. Зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрт байрлах аймаг, нийслэл, сум, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бусад зөвлөлүүдтэй мэргэжил, арга зүйн чиглэлээр хамтран ажиллана.
- 1.4. Зөвлөл нь хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр боловсруулан баталж, үйл ажиллагааныхаа тайланг хагас болон бүтэн жилээр гаргана.
- 1.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус салбар зөвлөл нь үйл ажиллагааныхаа тайлан мэдээг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус төв зөвлөлд хүргүүлнэ.
- 1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус төв зөвлөл нь их сургуулийн хэмжээний тайлан мэдээг нэгтгэнэ. Шаардлагатай бол тухайн дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, бүрэлдэхүүн

- 2.1. Их сургуулийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан “ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус төв зөвлөл”, бүрэлдэхүүн, салбар сургууль тус бүр тухайн нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус салбар зөвлөл”-ийг байгуулан ажиллуулна.
- 2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус төв зөвлөлийг ректорын, бүрэлдэхүүн, салбар сургууль дээр ажиллах салбар зөвлөлийг тухайн сургуулийн захирлын тушаалаар тус тус байгуулна.
- 2.3. Зөвлөлүүд нь тухайн нэгжийн ажилтны тооноос хамааран ажил олгогчийн болон ажилтны төлөөллийг (ажилтныг төлөөлж үйлдвэрчний эвлэлийн гишүүн байна)



оролцуулсан, талуудын тэгш оролцоог хангасан 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байна. Бүрэлдэхүүнд оролцогч талууд ижил тэгш эрх, үүрэгтэй оролцоно.

- 2.4. “ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус төв зөвлөл”-ийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан чиг үүрэг бүхий захиргааны нэгжийн дарга ахална.
- 2.5. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус салбар зөвлөл”-ийг тухайн бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал удирдана.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл

- 3.1. “ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус төв зөвлөл” нь дараах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.1.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого, төлөвлөгөө, шаардлагатай дүрэм, журмыг боловсруулах, шинэчлэх;
- 3.1.2. Их сургуулийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахад оролцох, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг мөрдүүлэхэд санал өгөх;
- 3.1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах;
- 3.1.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагатай төсөв, тооцооны саналыг боловсруулах, нэгтгэх;
- 3.1.5. Их сургуулийн хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;
- 3.1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган, ажил олгогч, салбар зөвлөлүүдтэй хамтран хийх;
- 3.1.7. Их сургуулийн хэмжээнд ажлын хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ажлын байрны орчин нөхцөл, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн эмчилгээ, сувилгаатай танилцах, шаардлагатай бол хоолны чанарт хяналт тавих, үр дүнг мэдээлэх;
- 3.1.8. Мэргэжлийн онцлогоос хамааруулан, ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- 3.1.9. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус салбар зөвлөл”-ийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- 3.1.10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус төв болон салбар зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийг чадавхжуулах арга хэмжээг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;
- 3.1.11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа талаар ажил олгогчийн тайлан мэдээллийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, шаардлагатай бол зөвлөмж гаргах;
- 3.1.12. Хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;



- 3.2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус салбар зөвлөл” нь дараах үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэгжийн хэмжээнд хангуулах ажлыг зохион байгуулах;
 - 3.2.2. Хариуцсан нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв, тооцооны судалгааг хийх;
 - 3.2.3. Хариуцсан нэгжийн ажлын байрны орчин, хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, эрсдэлийн түвшинг тогтоох, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлэх, шаардлагатай бүртгэл судалгааг хийх, нэгдсэн тайлан мэдээг төв зөвлөлд хүргүүлэх;
 - 3.2.4. Нэгжийн түвшинд эрсдэл ихтэй ажлын байр, лабораторийн ажиллах орчны аюулгүй ажиллагааны заавар, зөвлөмжүүдийг мөрдүүлэх, холбогдох хяналтыг хэрэгжүүлэх;
 - 3.2.5. Шаардлагатай ажилтнуудыг ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангах үйл ажиллагаанд хяналт тавих;
 - 3.2.6. Нийт ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах үйл ажиллагааг дангаар болон бусад талуудтай хамтран зохион байгуулах;
 - 3.2.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөөн, сургалт, семинарыг хариуцсан нэгжийн түвшинд зохион байгуулах;
 - 3.2.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төв болон бусад салбар зөвлөлүүдтэй хамтран ажиллах;
 - 3.2.9. Хууль тогтоомжид заасан бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Дөрөв. Зөвлөлийн хурал

- 4.1. Зөвлөл нь их сургуулийн хэмжээнд болон хариуцсан нэгжийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар хэлэлцүүлэг хийх, зөвлөлдөх, зөвлөмж, санал гаргах, шаардлага өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад оролцох чиглэлээр ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хамтран ажиллах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.
- 4.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Зөвлөлийн хурлыг улиралд нэг удаа хийнэ. Хурлыг зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.
- 4.3. Зөвлөлийн хурлыг нийт гишүүдийн 50-иас дээш хувийн ирцтэй хийнэ.
- 4.4. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан их сургуулийн захиргааны, тухайн нэгжийн болон бусад холбогдох ажилтныг хуралд оролцуулж болно.
- 4.5. Зөвлөл нь зөвлөмжийн шинжтэй шийдвэр гаргах бөгөөд ажил олгогчид санал, зөвлөмж хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй байна.
- 4.6. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн аливаа асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Хурлын тэмдэглэлийг тухай бүр хөтөлнө.